

Маягт СЗХ04008

**Даатгалын бүтээгдэхүүний мэдэгдлийн маягт**

1	Мэдэгдэл огноо	Он	2021	Сар	03	Өдөр	29
2	Мэдэгдэл гаргагчийн оноосон нэр	Амар Даатгал ХХК					
3	Даатгалын бүтээгдэхүүний нэр	Байгууллагын хариуцлагын даатгал					
4	Даатгалын бүтээгдэхүүний холбогдох даатгалын хэлбэр	Хариуцлагын даатгал					
5	Даатгалын бүтээгдэхүүнийг борлуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр	Шийдвэрийн нэр		Огноо		Дугаар	
		Даатгалын бүтээгдэхүүн шинэчлэн батлах тухай		2021-02-05		ЗТ-21/02-016	
6	Цахимаар борлуулах эсэх	Үгүй					
7	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Овог		Нэр			
		Доржготов		Уранцэцэг			
<b>Мэдээллийн төрлийг сонгоно уу.</b>							
8	Даатгалын бүтээгдэхүүнийг шинэчлэх						
<b>Даатгалын бүтээгдэхүүний ерөнхий мэдээлэл</b>							
9	Даатгалын зүйл	Даатгуулагчийн санаатай бус болгоомжгүй үйлдлийн улмаас болон үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үзүүлсэн үйлчилгээний шууд нөлөөллөөс шалтгаалан гуравдагч этгээдийн амь нас эрүүл мэнд					
	Даатгалын үндсэн эрсдэл	Санамсар болгоомжгүй үйлдэл					
	Даатгалын нэмэлт эрсдэл						
	Даатгалын хураамжийн хувь, хэмжээ	0.1%-1%					

Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Даатгалын багц дүрэмд нийцүүлэн мэдэгдлийг үнэн зөв бөглөж, хүргүүлэв. Дээр мэдэгдсэн зүйл нь ямар нэг худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг бид хүлээх болно.

## ДААТГАЛД ХАМРАГДАХГҮЙ НӨХЦӨЛҮҮД

1. Даатгуулагч, түүний ажилтны гэмт хэрэг, зөрчлийн шинж чанар, зорилготойгоор санаатай үйлдсэн үйлдлийн улмаас учруулсан аливаа хохиролд;
2. Гэрээнд өөрөөр заагаагүй бол даатгалын зүйлд гарсан хохирлоос үүдэн даатгуулагчид болон хохирогч гуравдагч этгээдэд гарсан эдийн засгийн алдагдалд;
3. Даатгалын тохиолдлын улмаас газар, шороо, хөрс, агаар, газрын хэвлийн болон байгаль орчинд учирсан хохиролд;
4. Гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын нутаг дэвсгэрээс гадна учирсан аливаа хохиролд;
5. Даатгуулагч, түүний ажилтны согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн үед хийсэн үйлдлийн улмаас үүдсэн хохиролд;
6. Үйлчлүүлэгчийн худалдан авсан бүтээгдэхүүн ба үйлчилгээний үнэ өртөгт;
7. Замын тээврийн ослын улмаас учирсан хохиролд;
8. Даатгуулагчид өөрт нь учирсан бүх төрлийн хохиролд;
9. Гадаад улс оронд тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэй холбоотой шалтгаанаас үүдэн гарсан хохиролд;
10. Даатгалын тохиолдолд хохирогч гуравдагч этгээд буруутай болох нь тогтоогдсон бол;
11. Хууль, дүрэм журам, үйлдвэрлэлийн стандарт, технологийг илтэд эсхүл санаатай зөрчин үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн ба үзүүлсэн үйлчилгээ, үйл ажиллагаа явуулсны улмаас учирсан хохиролд;
12. Эрх бүхий байгууллагаас олгогдох тусгай зөвшөөрлийн үндсэн дээр хийгдэх үйлдвэрлэл, үйлчилгээг зохих зөвшөөрөлгүйгээр болон зөвшөөрлийн хугацаа дууссан байхад үйлдвэрлэл, үйл ажиллагаа явуулсан, үйлчилгээ үзүүлснээс үүдэн гарсан хохиролд;
13. Даатгуулагчийн ажлын байрандаа зохих хамгаалалт, хяналтгүй орхиж явсан машин механизм, тоног төхөөрөмж, материал, химийн бодисоос шалтгаалан гарсан хохиролд;
14. Хадгалалтын горимыг илтэд зөрчсөнөөс үүдэн гарсан хохиролд;
15. Бүтээгдэхүүний ашиглалтын хүчинтэй хугацаа дууссанаас үүдэн гарсан хохиролд;
16. Хэрэглэгч тухайн бүтээгдэхүүн болон үйлчилгээний хэрэглэх зааврыг зөрчсөнөөс үүдэн гарсан хохиролд;
17. Даатгуулагчийн гуравдагч этгээдтэй байгуулсан гэрээний дагуу төлөгдөх анз, дэнчин, баталгаа, эрх бүхий байгууллагаас ногдуулсан торгууль, төлбөр;
18. Халдварт өвчнөөр өвчилсөн ажилтнаас үүдэн гарсан хохиролд;
19. Даатгуулагчид эрх бүхий байгууллагаас ногдуулсан торгууль, шийтгэвэр;
20. Тусгай мэдлэг, мэргэшил шаардсан ажил албан тушаалд мэргэжлийн бус ажилтныг ажиллуулснаас үүдсэн хохиролд;
21. Эрх бүхий байгууллагаас үйлдвэрлэх болон борлуулахыг хориглосон бүтээгдэхүүн ба үйлчилгээнээс үүдэн гарсан хохиролд;
22. Зөвшөөрөл бүхий талбай, цэгээс бусад газарт үйлдвэрлэл, үйл ажиллагаа явуулнаас үүдэн гарсан хохиролд;
23. Даатгуулагчийн өөрийн үйлдвэрлээгүй импортоор оруулж ирсэн бэлэн бараа бүтээгдэхүүнийг албан ёсны дистрибьютерээр худалдан борлуулаагүйгээс үүдсэн хохиролд;
24. Үйлдвэрийн техник тоног, төхөөрөмжийн ашиглалтын горим, зааврыг зөрчсөн, даац, ачаалал хэтрүүлснээс үүссэн хохиролд;
25. Хууль тогтоомжид заасан бусад.